ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Асралт-Үйлс эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/149/СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас:70584203 Цахим хаяг:Bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 70584204 Цахим хаяг:SemjidmaaI@audit.gov.mn<br>Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн<br>Утас: 70584204 Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ДОА | Дорнод аймаг |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| БГБХН | Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл |
| ЖДААНОУС | Жижиг Дунд Аж Ахуйн Нэгжийн Олон Улсын Стандарт |

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт........................................................................................3-4

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..........................................................................................5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.......................................................................5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....................................................................5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..........................................................................7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.............................................8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан......................................................................9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..................................................................10

3. Аудитын тайлан......................................................................................................................11

3.1. Ерөнхий зүйл.........................................................................................................................11

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй..................................................11

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.......................................................11

3.4. Материаллаг байдал.............................................................................................................11

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд................................................................................11

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.......................................................11

3.7. Шилэн дансны мэдээлэл.....................................................................................................11

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..........................................................................................12

3.9. Аудитын илрүүлэлт..............................................................................................................12

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил........................................12

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд...........................................................................................................13

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт...................................................................13

**1.Хараат бус аудиторын дүгнэлт**

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 315

танай ____________-ны №______________-т

АСРАЛТ-ҮЙЛС ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.АЛТАНТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төв 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 85.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020316

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **36197971.28** | **71094370.90** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2103508.36 | 20198949.95 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 9042.86 | 0.01 |
| 31110 | Төгрөг | 9,042.86 | 00.01 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 2,094,465.50 | 20,198,949.94 |
| **3121** | **Төгрөг** | 2094465.50 | 20198949.94 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 2,094,465.50 | 20,198,949.94 |
| **33** | **АВЛАГА** | 132,083.75 | 8,570.95 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 2,244.70 | 690.66 |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | 129,839.05 | 7,880.29 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 33962379.17 | 50886850.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 10872082.17 | 15616598.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 10,872,082.17 | 15,616,598.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 00.00 | 1,403,778.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 23090297.00 | 33866474.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 21,998.00 | 863,098.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,068,299.00 | 33,003,376.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **292080160.45** | **322338249.18** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 292080160.45 | 322338249.18 |
| **392** | **Биет хөрөнгө** | 292080160.45 | 322338249.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 236,571,479.71 | 236,571,479.71 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -5,914,286.99 | -11,828,573.98 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 29,500,000.00 | 29,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -29,500,000.00 | -29,500,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 98,318,549.00 | 147,704,549.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -46,772,566.50 | -61,541,396.50 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,037,540.00 | 22,187,540.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,510,840.50 | -11,088,954.50 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 366,966.00 | 366,966.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -16,680.27 | -33,360.55 |
| 39301 | Програм хангамж | 645,866.00 | 645,866.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -645,866.00 | -645,866.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **328278131.73** | **393432620.08** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-0.01** | **0.01** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | -0.01 | 0.01 |
| **413** | **Өглөг** | -0.01 | 0.01 |
| **4136** | **Бусад өглөг** | -0.01 | 0.01 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 00.00 | 00.02 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **328278131.73** | **393432620.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 328278131.73 | 393432620.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 758500615.97 | 758500615.97 |
| 51101 | Өмч: - төрийн | 677,468,961.00 | 758,500,615.97 |
| 51102 | - хувийн | 50,087,218.47 | 00.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -43758959.01 | 21395529.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -43,758,959.01 | -43,758,959.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 65,154,488.58 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | -386,463,525.23 | -386,463,525.23 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **328278131.72** | **393432620.33** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **323210943.64** | **518703343.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **52497243.64** | **61877143.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 52497243.64 | 61877143.32 |
| 120009 | Бусад орлого | 52,497,243.64 | 61,877,143.32 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **270713700.00** | **456826200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 224560900.00 | 406699800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 224560900.00 | 406699800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **46152800.00** | **50126400.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 46152800.00 | 50126400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **323230005.32** | **453548854.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **323230005.32** | **453548854.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 323230005.32 | 453548854.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 167881407.00 | 242983642.00 |
| 210101 | Үндсэн цалин | 167,881,407.00 | 242,983,642.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **21413027.74** | **14308306.57** |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 21,413,027.74 | 14,308,306.57 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **7457670.00** | **9358657.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,284,613.00 | 1,608,663.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3467787.00 | 3539060.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,014,022.00 | 1,286,930.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,691,248.00 | 2,924,004.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **32998203.21** | **31216717.61** |
| 210401 | Бичиг хэрэг | 16,329,576.00 | 24,162,539.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,687,441.00 | 2,596,705.85 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,251,186.21 | 1,200,172.76 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 12730000.00 | 3257300.00 |
| **2105** | **Норматив зардал** | **62275977.11** | **107111683.17** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62275977.11 | 107111683.17 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1213800.00** | **564000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,213,800.00 | 564,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **516800.00** | **548622.89** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 359,400.00 | 359,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,200.00 | 79,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 78,200.00 | 110,022.89 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **29473120.26** | **47457225.49** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,193,193.72 | 24,669,314.23 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 560,000.00 | 510,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,719,926.54 | 22,277,911.27 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-19061.68** | **65154488.59** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-19061.68** | **65154488.59** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **279356638.79** | **457548922.10** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8642938.79** | **722722.10** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 8642938.79 | 722722.10 |
| 120009 | Бусад орлого | 8,642,938.79 | 722,722.10 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **270713700.00** | **456826200.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 224560900.00 | 406699800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 224560900.00 | 406699800.00 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **46152800.00** | **50126400.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 46152800.00 | 50126400.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **277351384.50** | **440894118.51** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **277351384.50** | **440894118.51** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **277351384.50** | **440894118.51** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 138552862.57 | 212069780.70 |
| 210101 | Үндсэн цалин | 138552862.57 | 212069780.70 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **40948617.22** | **26529267.30** |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 40,948,617.22 | 26,529,267.30 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **12816885.81** | **17712520.66** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,284,613.00 | 1,608,663.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3467787.00 | 3539060.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,014,022.00 | 1,286,930.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,691,248.00 | 2,924,004.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 5,359,215.81 | 8,353,863.66 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **72959381.50** | **163821264.85** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4117442.00 | 2926705.85 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 68,841,939.50 | 160,894,559.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12073637.40** | **20761285.00** |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 10,894,637.40 | 19,481,105.00 |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/ | 1,179,000.00 | 1,274,780.00 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 00.00 | 5,400.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2005254.29** | **16654803.59** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 4 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **6736611.00** | **12170469.00** |
| 140002 | Улсын төсвөөс олгосон зээл | | |
| 140003 | Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт | 6,736,611.00 | 12,170,469.00 |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6736092.00** | **10729831.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6736092.00** | **10729831.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 6736092.00 | 10729831.00 |
| 225105 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/ | 6,736,092.00 | 10,729,831.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **519.00** | **1440638.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2005773.29 | 18095441.59 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 97,735.07 | 2,103,508.36 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,103,508.36 | 20,198,949.95 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 727,556,179.47 | -386,463,525.23 | -43,758,959.01 | 30,944,436.50 | 328,278,131.73 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **727,556,179.47** | **-386,463,525.23** | **-43,758,959.01** | **30,944,436.50** | 328,278,131.73 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 0.00 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **727,556,179.47** | **-386,463,525.23** | **-43,758,959.01** | **30,944,436.50** | 328,278,131.73 |
| D01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **727,556,179.47** | **-386,463,525.23** | **-43,758,959.01** | **30,944,436.50** | 328,278,131.73 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **727,556,179.47** | **-386,463,525.23** | **-43,758,959.01** | **30,944,436.50** | 328,278,131.73 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 65,154,488.58 | 00.00 | 65,154,488.58 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **727,556,179.47** | **-386,463,525.23** | **21,395,529.57** | **30,944,436.50** | 393,432,620.31 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төловлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **455,278,300.00** | **440,894,118.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **455,278,300.00** | **440,894,118.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **455,278,300.00** | **440,894,118.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **226,449,100.00** | **242,983,642.00** |
| 210101 | Үндсэн цалин | 226,449,100.00 | 242,983,642.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **28,306,100.00** | **14,308,306.57** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **9,110,000.00** | **9,358,657.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,160,000.00 | 1,608,663.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,550,000.00 | 3,539,060.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,400,000.00 | 1,286,930.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 2,924,004.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,180,000.00** | **31,216,717.61** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,600,000.00 | 24,162,539.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,596,705.85 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,920,000.00 | 1,200,172.76 |
| 210404 | Ном, хэвлэл | 360,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,257,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **97,567,000.00** | **89,378,172.44** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 96,367,000.00 | 89,378,172.44 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,200,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **63,675,500.00** | **52,536,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,939,100.00 | 49,386,000.00 |
| 210602 | Тавилга | | 3,150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,736,400.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,520,000.00** | **564,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,520,000.00 | 564,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,359,200.00** | **548,622.89** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,140,000.00 | 359,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,200.00 | 79,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 96,000.00 | 110,022.89 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,111,400.00** | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,111,400.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **455,278,300.00** | **457,548,922.10** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **406,699,800.00** | **406,699,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 406,699,800.00 | 406,699,800.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИ** | **48,578,500.00** | **50,126,400.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 48,578,500.00 | 50,126,400.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | **722,722.10** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 722,722.10 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **29.00** | **29.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26.00 | 26.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **29.00** | **29.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 26.00 | 26.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 3.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

БГБХН тул нэмэлт дансаар гүйлгээ хийдэггүй.

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга С.Алтантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд он дамжсан авлагын үлдэгдэлтэй байгаад анхаарах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Оюунхэрлэн хариуцаж хэрэгжүүлэв.

**Commented [MA1]:** БАГ ОРУУЛАХ-ХЭРХЭН ЯАЖ?

**Commented [TR2R1]:** Ахлах аудиторыг оруулах.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж, өрх иргэн бүрд нийгмийн болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ур чадварын өндөр түвшинд хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх зөв дадлыг эзэмшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон ЖДААНОУС түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.

Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 453,548.8 мянган төгрөгөөс тооцон 9,071.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 9,071.0 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,154.5 мянган төгрөгөөр буюу 19.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,103.5 | 20,198.9 | 18,095.4 |
| Авлага | 132.0 | 8.6 | -123.4 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 33,962.4 | 50,886.9 | 16,924.5 |
| Үндсэн хөрөнгө | 292,080.2 | 322,338.2 | 30,258.0 |
| **Нийт хөрөнгө** | **328,278.1** | **393,432.6** | **65,154.5** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | **0.0** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 328,278.1 | 393,432.6 | **65,154.5** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **328,278.1** | **393,432.6** | **65,154.5** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 20,198.9 мянган төгрөг болж 18,095.4 мянган төгрөгөөр өссөн нь оношилгооны тоног төхөөрөмж авах захиалга өгсөн боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж тоног төхөөрөмж нь ирээгүй байгаатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 50,886.9 мянган төгрөг болж 16,924.5 мянган төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой бэлэн байдалд зориулж эм тариа, багаж хэрэгсэл авч бэлдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 322,338.2 мянган төгрөг болж 65,154.5 мянган төгрөгөөр өссөн нь 52,538.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр данс нь үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 393,432.6мянган төгрөг болж 65,154.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 195,492.4 мянган төгрөгөөр буюу 1.6 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын шилжүүлгийн орлого байна. Энэ нь нэг иргэнд ногдох эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний дундаж зардал өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 130,287.0 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт цалин хөлс, норматив зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь Засгийн газраас цалин хөлс нэмсэн, нэг иргэнд ногдох эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний дундаж зардал өссөнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 455,278.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 455,278.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 455,278.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 406,700.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 48,578.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 406,700.3 мянган төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас 50,126.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 440,894.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төв нь нэмэлт дансаар гүйлгээ хийдэггүй бөгөөд орлого зарлагын нэг дансаар гүйлгээ хийдэг онцлогтой байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 12 мэдээллээс хугацаандаа оруулсан 12 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81,031.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 81,031.6 мянган төгрөгийн алдааг залруулж, нэг зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгө, өмчийн хэсгийн Засгийн газрын хувь оролцоо үзүүлэлтийн хувийн өмчийн дансанд бичигдсэн 50,087.2 мянган төгрөг, эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансанд бичигдсэн 30,944.4 мянган төгрөг, нийт 81,031.6 мянган төгрөгийг байдлын тайлангийн цэвэр хөрөнгө, өмчийн хэсгийн Засгийн газрын хувь оролцоо үзүүлэлтийн Төрийн өмчийн дансанд залруулж бичив.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана*" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020

Аудитын нэр: ***Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ДОА-2021/149/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: ***Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төв***

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй | 0 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | С.Алтантуяа Л.Лхамтуяа |
| **ДҮН** | | **0** | | | |